

**ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2009 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2010.03.25

Улиастай

Нэг. Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ

1.Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт: Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын орон нутагтай холбоотой 27 зорилтын 232 арга хэмжээг хяналтад авч, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. 2009 оны эцсийн дүнгээр 26,21 хувийн хэрэгжилттэй байна.

Аймгийн 2009-2021 оны Хөгжлийн цогц бодлогыг боловсруулж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан зарим асуудлыг хэрэгжүүлж эхлээд байна.

2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт: Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тус аймагтай холбоотой тусгагдсан 171 заалтыг хяналтад авч хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж байна. Хөтөлбөрийн хэрэгжилт 2009 оны гүйцэтгэлээр 41.05 хувьтай дүгнэгдэж, бүрэн хэрэгжсэн 7, 90.0 хувьтай 3, 70.0 хувьтай 4, 50.0 хувьтай 70, 30.0 хувьтай 70, 10.0 хувьтай 13, хэрэгжиж эхлээгүй 3, хугацаа болоогүй 1 заалт байна. Хугацаагаар нь авч үзвэл: 2008-2012 онд хэрэгжүүлэх 19 заалт 40.0 хувь, 2009 онд хэрэгжүүлэх 7 заалт 91,4 хувь, 2009-2010 онд хэрэгжүүлэх 16 заалт 38.75 хувь, 2009-2011 онд хэрэгжүүлэх 3 заалт 36.6 хувь, 2009-2012 онд хэрэгжүүлэх 116 заалт 37.6 хувь, 2010 онд хэрэгжүүлэх 1 заалт 50.0 хувь, 2010-2011 онд хэрэгжүүлэх 1 заалт 30.0 хувь, 2010-2012 онд хэрэгжүүлэх 6 заалт 50.0 хувийн хэрэгжилттэй байна. 2009 онд хэрэгжүүлэх аймгийн төвүүдийн дулаан хангамжийн байдалд судалгаа хийж, шинэчлэлтийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах арга хэмжээний хэрэгжилт удаашралтай, бусад зорилтууд хугацаандаа хэрэгжиж байна.

3.Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт: Аймгийн хэмжээнд Засгийн газраас баталсан 97 үндэсний хөтөлбөрийг хяналтад авч, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж байна. Үндэсний хөтөлбөрүүдийн тайланг Засгийн газрын 2006 оны 160 дугаар тогтоол, 2009 оны 285 дугаар тогтоолын дагуу гаргаж, хяналт-шинжилгээ үнэлгээ хийхэд 2009 оны гүйцэтгэл 94.3 хувьтай дүгнэгдэж, 100,0 хувьтай 55, 90,0 хувьтай 30, 70,0 хувьтай 8, 50,0 хувьтай 1, хугацаа болоогүй 3 хөтөлбөр байна. Үндэсний хөтөлбөрүүд хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацааны гүйцэтгэл 62,6 хувьтай, эдгээрээс 100,0 хувьтай 1, 90,0 хувьтай 16, 70,0 хувьтай 38, 50,0 хувьтай 27, 30,0 хувьтай 11, 10,0 хувьтай 1, хугацаа болоогүй 3, хэрэгжилт нь удаашралтай байгаа 16 хөтөлбөр байна. Хэрэгжилт нь удааширалтай байгаа

хөтөлбөрүүдийн 9 нь байгаль орчны салбарын, 5 нь үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлийн, 1 нь газар тариалангийн, 1 нь барилгын салбарын хөтөлбөр байгаа бөгөөд мэдээллийг тусад нь гаргаж хүргүүлж байна. Үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд 2009 онд нийт 8450.6 сая төгрөг зарцуулсны 3035.5 сая төгрөг нь улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалт, 1320.7 сая төгрөг нь салбар яамны төсөв, 4049.4 сая төгрөг нь орон нутгийн төсөв болон бусад эх үүсвэрээс бүрдэж байна. Салбарын яамдаас зарцуулсан хөрөнгийн 3.4 хувь нь буюу Эрүүл мэндийн сайдын багцын 45.0 сая төгрөгийг хөтөлбөр хэрэгжүүлэхэд зориулж төсөвлөж, зарцуулсан бөгөөд бусад нь хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны зардал байна. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд яамдаас орон нутагт тусгай хөрөнгө төсөвт тусгахгүй, зөвхөн байгууллагын үйл ажиллагааны зардлаар зохион байгуулсан арга хэмжээгээр гүйцэтгэлийг дүгнэж байна. Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн дэлгэрэнгүй тайланг аймгийн Засаг даргын 2010 оны 3 дугаар сарын 23-ний өдрийн 2а/243 тоот албан бичгээр тусад нь хүргүүлсэн.

Хоёр. Бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын үнэлгээ

1. Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2009 оны үндсэн

чиглэлийн биелэлт: Үндсэн чиглэлд тус аймагтай холбоотой 8 заалт тусгагдсаныг хэрэгжүүлж, 6 заалт 100,0 хувийн, 2 заалт 90,0 хувийн, нийт дүнгээр 97,4 хувийн биелэлттэй байна.

2.Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт: Монгол Улсын Засгийн газрын 1996 оны 66 дугаар тогтоол, 2006 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн орон нутагт даалгасан заалтуудыг хяналтад авч, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулан биелэлтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, танилцуулгыг улирал тутам Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Сум, баг, хэлтэс, агентлаг, албан байгууллагуудад Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх, биелэлтийг дүгнэж, мэдээлэх журмыг боловсруулж, аймгийн Засаг даргын захирамжаар батлуулан хэрэгжүүлж байна. Аймгийн хэмжээнд 2009 оны 4 дүгээр улирлын байдлаар Засгийн газрын 90 тогтоолын 132 заалт, Засгийн газрын хуралдааны 19 тэмдэглэлийн 26 заалт, Засгийн газрын 6 албан даалгаварын 20 заалт, Ерөнхий сайдын 5 захирамжийн 5 заалт, нийт 120 шийдвэрийн 183 заалтыг хяналтад авч хэрэгжүүлэн, үр дүнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийхэд гүйцэтгэл 91,44 хувьтай, бүрэн хэрэгжсэн заалт 118, хэрэгжих шатандаа 63, хугацаа болоогүй 2 заалт байна. Хэрэгжих шатандаа байгаа 63 заалтаас 90,0 хувьтай 26 заалт, 70,0 хувьтай 29 заалт, 50,0 хувьтай 7 заалт, 30,0 хувьтай 1 заалт, хэрэгжилт нь удааширч байгаа 7 заалт байна. Засгийн газрын шийдвэрийн 2009 оны дэлгэрэнгүй танилцуулга, хэрэгжилт нь

удааширсан заалтуудын тухай мэдээллийг аймгийн Засаг даргын 2010 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 26/10 тоот албан бичгээр хүргүүлсэн.

3.Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн хэрэгжилт: Аймгийн Засаг дарга бүрэн эрхийнхээ хугацаанд Монгол Улсын Ерөнхий сайдын өмнө 8 чиглэлийн үүргийг батламжаар хүлээн хэрэгжүүлж, биелэлтийн тайланг хагас бүтэн жилд Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж байна. Батламжийн биелэлт 2009 онд 100 хувь хэрэгжиж, тайланг аймгийн Засаг даргын 2010 оны 1 дүгээр сарын 13 –ны өдрийн 2а/23 тоот албан бичгээр хүргүүлсэн.

4.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт: Аймгийн Засаг даргын 2008-2012 оны үйл ажиллаганы хөтөлбөрт Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, орон нутгаа хөгжүүлэх, төрийн үйлчилгээг сайжруулах, иргэд, олон нийтийн идэвхи санаачлагыг өрнүүлж, амьдралын түвшинг дээшлүүлэхэд чиглэгдсэн 4 бүлэг, 196 зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлж, эрүүл мэнд спортын бодлогын 21 зорилт 38,5 хувь, боловсрол, соёлын бодлогын 25 зорилт 51,6 хувь, нийгмийн хамгаалал хүн амын бодлогын 26 зорилт 42,1 хувь, үйлдвэржүүлэлтийн бодлогын 8 зорилт 42,5 хувь, хүнсний аюулгүй байдал, худалдаа үйлчилгээний бодлогын 13 зорилт 39,2 хувь, дэд бүтэц, хот байгуулалтын бодлогын 21 зорилт 36,2 хувь, хөдөө аж ахуйн бодлогын 14 зорилт 30,7 хувь, байгаль орчны тэнцвэрт харьцааг хангах бодлогын 15 зорилт 32,6 хувь, банк, санхүү татварын бодлогын 11 зорилт 35,4 хувь, эрх зүйн бодлогын 7 зорилт 41,4 хувь, гэмт хэрэгтэй тэмцэх, хил хамгаалах бодлогын 10 зорилт 55,0 хувь, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх бодлогын 3 зорилт 10,0 хувь, иргэний нийгэм, төрийн удирдлагын бодлогын 12 зорилт 37,5 хувийн биелэлттэй, эдгээрээс 100 хувь хэрэгжсэн 3, 90,0 хувь хэрэгжсэн 4, 70,0 хувь хэрэгжсэн 19, 50,0 хувь хэрэгжсэн 64, 30,0 хувь хэрэгжсэн 82, 10,0 хувь хэрэгжсэн 12, хугацаа болоогүй 12 зорилт байна. 2009 оныг “Улиастай хотын тохижилт бүтээн байгуулалтын жил” болгон зарлаж, бүтээн байгуулалтын томоохон арга хэмжээнүүдийг зохион байгуулж, үйлдвэр үйлчилгээ, жижиг дунд үйлдвэрүүдийг боломжтой бүх талаар дэмжин хамтарч ажиллаа. Аймгийн хэмжээнд 2010 оныг сумдын “Бүтээн байгуулалт, үйлдвэржилт, тохижилтын жил” болгон зарлаж, сум багт хэрэгжүүлэх ажлын жагсаалт гарган ажиллаж байна. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2009 оны зорилтуудыг хэрэгжүүлэхээр аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд 5 бүлэг, 33 зорилт бүхий 219 арга хэмжээг төлөвлөж, эдгээрийн 189 нь бүрэн хэрэгжсэн, 23 хэрэгжих шатандаа, 5 нь хэрэгжилт удааширалтай, 2 асуудал хэрэгжээгүй байна. Улиастай сумын цахилгаан эрчим хүчний шугамын шинэчлэлтийг эхлүүлэх асуудал хөрөнгийн эх үүсвэр оройтож, шийдвэрлэгдсэнээс хойшлогдож, “Алтан намар-

2009” хүүхдийн урлаг, спортын наадам гахайн томууны ханиаднаас шалтгаалан тасарсан. Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Яам болон аймаг, нийслэлийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам”-ын дагуу дүгнэхэд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр 38,9 хувийн, аймгийн эдийн засаг нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэл 95,6 хувийн биелэлттэй байна.

Гурав. Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ

1. Эрхлэх асуудлын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт:

Аймгийн Засаг дарга 2009 онд Монгол Улсын тэргүүн шадар сайд, шадар сайд болон 9 салбарын сайдтай бүтээгдэхүүн нийлүүлж, санхүүжилт авах гэрээ байгуулж, хэрэгжүүлэн биелэлт, үр дүнг яамдын дүгнэсэн дүнгээр мэдээлж байна.

-Тэргүүн шадар сайдтай байгуулсан гэрээний биелэлт 100.0 хувьтай

-Монгол Улсын шадар сайдтай байгуулсан гэрээний биелэлт 90.0 хувьтай.

-Хууль зүй, дотоод хэргийн сайдтай байгуулсан гэрээний биелэлт 92.8 хувьтай

-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдтай байгуулсан гэрээний биелэлт 94.5 хувьтай

-Эрдэс баялаг, эрчим хүчний сайдтай байгуулсан гэрээний биелэлт 100.0 хувьтай

-Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдтай байгуулсан гэрээний биелэлт 94.0 хувьтай

-Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай байгуулсан гэрээний биелэлт 100.0 хувьтай

-Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдтай байгуулсан гэрээний биелэлт 92.0 хувьтай

-Эрүүл мэндийн сайдтай байгуулсан гэрээний биелэлт 73.9 хувьтай

-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны сайдтай байгуулсан гэрээний биелэлт 85.3 хувьтай

-Батлан хамгаалахын сайдтай байгуулсан гэрээний биелэлт 94.1 хувьтай байна.

Засгийн газрын 2010 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу манай аймгийн Засаг дарга “Төсвийн ерөнхийлөн захирагчидтай аймгийн Засаг даргын байгуулж байгаа гэрээний хэрэгжилт, цаашид анхаарах асуудлын тухай” сэдвээр 4 дүгээр сард Засгийн газрын хуралдаанд мэдээлэл хэлэлцүүлэх тул бэлтгэл ажлыг хангаж, тодорхой арга хэмжээ зохион байгуулж, мэдээлэл болон цаашид орон нутагт авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай шийдвэрийн төслийн саналаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Орон нутгийн удирдлагын хэлтэст хүргүүлсэн.

2.Төсвийн ерөнхийлөн захирагчаас Ерөнхий менежертэй байгуулсан үр

дүнгийн гэрээний биелэлт: Аймгийн Засаг даргаас Засаг даргын Тамгын газрын дарга буюу төсвийн Ерөнхий менежертэй 2009 онд 17 бүтээгдэхүүний ангийн 175 нийт бүтээгдэхүүн, 32 тусгай захиалгат бүтээгдэхүүн нийлүүлэхээр гэрээ байгуулж, өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх 4 зорилтыг ханган нийт дүнгээр 95.9 хувийн биелэлттэй дүгнэгдлээ.

Дөрөв.Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ

1.Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал: Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй, шуурхай, шударга, хариуцлагатай, ажил хэрэгч байдлыг хангах арга хэмжээ авч байна. Үйл ажиллаганы ил тод, нээлттэй байдлыг хангах 7 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн дүн 97.4 хувь, үүнээс 5 үзүүлэлт 100,0 хувь, 2 үзүүлэлт 90.0 хувийн хэрэгжилттэй байна.

2.Хүний нөөцийн бодлогын ил тод байдал: Хүний нөөцийн бодлогын ил тод байдлыг хангах 6 шалгуур үзүүлэлтийн 4 нь бүрэн, 2 нь 90.0 хувьтай хэрэгжиж, нийт дүнгээр 96.6 хувийн биелэлттэй байна.

3.Төсөв, санхүүгийн ил тод байдал: Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах 7 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн дүн 97.4 хувь, үүнээс 5 үзүүлэлт 100,0 хувь, 2 үзүүлэлт 90.0 хувийн хэрэгжилттэй байна.

4.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ

худалдан авах ажиллагааны ил тод байдал: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлын 10 шалгуур үзүүлэлтийн 9 нь 100,0 хувь, 1 нь 70,0 хувь хэрэгжиж, нийт дүнгээр 97,0 хувийн биелэлттэй байна.

Тав. Үйл ажиллагааны үр дагаварын үнэлгээ

1.Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ: Аймгийн 2009 оны эдийн засгийн 19 үзүүлэлт 90.2 хувийн, нийгмийн 19 үзүүлэлт 92,2 хувийн, хөгжлийн 14 үзүүлэлт 97.2 хувийн, нийт дүнгээр 93.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.Хэрэглэгчийн үнэлгээ: Орон нутагт төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн талаар бүх сумдыг хамруулан 3116 хүнээс санал асуулга авч дүнг нэгтгэхэд ерөнхий үнэлгээ 93,6 хувьтай байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА П.НЯМЖАВ

